

Орхон бүсний пролетариат нар нэгдэж байна! АНХДУГААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 43 (2507) 1974 оны 6 дугаар сарын 3 ДАВАА

Дэлгэрхаан сумын намын үүрийн нарийн бичгийн дарга С.ЦЭНД, АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Л.МОЛОМ нарт

Таван сумын нам, улс, олон нийтийн байгуулла-
га, хамт олон, социалист уралдааныг өрнүүлж ул-
сын мах бэлтгэлийг төрөл бүрээр, ямааны доогуур
бэлтгэх төлөвлөгөөг 100-100,5 хувиар биелүүлсэн
явдалд Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх
захиргаа баяр хүргэж цаашидаж ахуй, соёлын тө-
лөвлөгөөт ажлуудаа хугацаанд нь биелүүлнэ гэд-
гт бат итгэж байна.

Аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн
дарга Ц.АДЬЯА
Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны
дарга Ч.ДАШДЭМБЭРЭЛ

АЙМГИЙН ИЛГЭЭЛТИЙН ЭЗДИЙН АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ

1974 оны 5 дугаар са-
рын 30. Зуунмод хотын
гудамж талбайд таримал
мод, бутууд навчис нахна-
гаа дэлгэн байгаа нь
өгөөж дэлгэр зуны улирал
эхэлсний шинж.

Өглөөний 9 цаг болоход
аймгийн Соёлын ордны
тайзны голд МХЗЭ-ийн
тэмдэг гялалзаж, МАХН-
ын Төв Хорооны нэгдү-
гээр нарийн бичгийн дар-
га, БНМАУ-ын Сайд на-
рын Зөвлөлийн дарга
Ю.Цэвэлбаян хөрөг зур-
гийг амьд цэцгээр чимж
арлуулал, «Манай залуу
найдаж хүлээлгэсэн
хүндэт зорилтыг нэр төр-
тэй биелүүлнэ гэдэгт ит-
гэж байна», «Аймгийн ил-
гээлтийн эздийн чуулга
уулзалтад оролцогчид
баяр хүргэе» гэсэн лоозун-
гуудаар чимэглэсэн хур-
лын тэргүүлэгчдийн байр-
наа БНМАУ-ын Ардын Их
Хурлын Тэргүүлэгч ги-
шүүн, МХЗЭ-ийн Төв Хо-
рооны нэгдүгээр нарийн
бичгийн дарга Ч.Пүрэв-
жав, МАХН-ын Төв Хо-
рооны гишүүн, аймгийн
Намын хорооны нэгдүгээр
нарийн бичгийн дарга
Ц.Адьяа, МХЗЭ-ийн Төв
Хорооны гишүүн, аймгийн
АДХ-ын гүйцэтгэх захир-
гааны дарга Ч.Дашдэм-
бэрэл нар болон аймгийн
Намын хорооны төрөө, АДХ-
ын гүйцэтгэх захир-
гааны гишүүд, БНМАУ-ын
хөдөлмөрийн баатар,
гавьяат цолтон, хувьс-
галт тэмцлийн ахмад зүт-
гэлтнүүдийг гарч ирэхэд
чуулга уулзалтад орол-
цогчид суудлаасаа босч
нижигнэтэл алга ташиж
угтлаа.

«Мөнх дурсагдах алдар»
гэсэн сэдэвт чуулга уул-
залтын ажиллагааг айм-

гийн ХЗЭ-ийн хорооны нэг-
дүгээр нарийн бичгийн
дарга П.Жанчив нээж
«Хөдөлмөр нэр төр, алдар
гавьяаны үйлс» гэсэн илгээ-
лтийг аймгийн Намын
хорооны хоёрдугаар на-
рийн бичгийн дарга,
Хувьсгалт тэмцлийн
ахмад зүтгэлтний зөвлө-
лийн дарга Д.Дамба-
жамц тавив.

Энэ чуулга уулзалтад
тус аймгаас төрсөн хөдөл-
мөрийн баатрууд, алдар
цолтнууд, хувьсгалт тэмц-
лийн ахмад зүтгэлтнүүд
дээс гадна илгээлтийн эз-
дийн төлөөлөгчид, Зуун-
мод хотын 8, 10 жилийн
дунд сургуулийн 7, 8
дугаар ангийг төгсөг-
чид, аймгийн төвийн албан
үйлдвэр, байгууллагын
дарга, эрхлэгчид оролц-
лоо. Чуулга уулзалт
дээр Өндөрширээт сум-
ын «Хөгжил» нэгд-
лийн тракторч, БНМАУ-ын
аварга хадланч илгээл-
тийн эзэн Н.Болд, Эрдэ-
нэ сумын «Туяа» нэгдлийн
мянгат саальчин, илгээл-
тийн эзэн Г.Мягмарсүрэн,
Алтанбулаг сумын
«Хөдөлмөр» нэгдлийн ямаа-
чин, илгээлтийн эзэн
Б.Дуламсүрэн, Сэргэлэн
сумын «Авдархангай» нэгд-
лийн ногоочин, илгээлтийн
эзэн Р.Сүхээ нарын 20 га-
руй хүн үг хэлэв.

БНМАУ-ын хөдөлмө-
рийн баатар, Жаргалантын
САА-н дарга нөхөр
Д.Аръяа хэлсэн үгэндээ:
Хөдөлмөрийн аль ч сал-
барт ажиллахдаа нэг төр-
лийн ажил мэргэжлийг
сонгон авч түүнийгээ он
удаан жил хийж дадлага-
жиж мэргэжнэс нь үлэмж
сайхан үр дүнд хүрдгийг
онцлон тэмдэглээд
БНМАУ-ын хөдөлмөрийн

баатар, Булган аймгийн
хоньчин Өчир гуай хонь
1 алхахад, хурга 7 алх-
даг. Иймээс хонь хурга-
ны алхалтыг тохируулж
хариулах нь хургыг сэн-
сэрч турахаас хамгаалах
нэг арга болдог гэж ярьж
байсан нь нэг төрлийн аж-
лыг олон жил хийж бая-
лаг туршлагатай болсны
илэрхийлэл мөн.

Залуу хүн бүр ажилд
ийм дадлагатай болтлоо
мэргэжнэ хэрэгтэй гэж
зөвлөдөө.

Дараа нь аймгийн АДХ-
ын гүйцэтгэх захиргааны
дарга Ч.Дашдэмбэрэл
илгээлтийн эзэд та бүхэн
бол аймаг, эх орноо хөг-
жүүлэх ирээдүйн их үйл-
сийг бүтээлцэх сайхан
хувь тавилантай хойч
үйснхэн юм.

Манай аймгийг хөгжүү-
лэх 20 жилийн техник
эдийн засгийн төлөвлө-
гөөг ЗХУ-ын мэргэжилт-
нүүд боловсруулс-
ныг МАХН-ын Төв Хороо-
ны Улс төрийн Товчоо
сайшааж БНМАУ-ын Сайд
нарын Зөвлөл баталсан
юм. Тус аймаг 1994 онд
1,7 сая гаруй малтай, 350
мянган га тариалангийн
талбайтай, жилдээ 100 га-
руй мянган тонн мах, 88
сая литр сүү үйлдвэрлэ-
дэг болж бүх САА
100 хувь, ХАА-н нэгд-
лүүдийн 60 хувь нь
төвдөө цахилгаан гэрэл,
соёл ахуйн бүх үйл-
чилгээгээр хангагдсан
байна. Бүх сум хоорондын
зам засагдаж асфальтагда-
на. Энэ бүх зүйлүүдийг
барьж байгуулахад 1 мил-
лиард 978 сая төгрөг зар-
цуулагдла. Энэ үед манай
аймаг 100 сая төгрөгийн
анигтай ажилладаг болох
юм. Ийм их үйлсийг бү-

тээн байгуулалцах эзэд
нь та нар болох юм.

Иймээс та нөхөд ахмад
үйснхээ нэр төртэй за-
луу халаа болж зорьсон
хэргээ амжилттай биес-
лүүлж мөнх дурсагдах
алдар гавьяатнууд болох
хэрэгтэй.

Мөн залуу хүмүүст юм
сурахад 3 саад байдаг
гэж сурган хүмүүжүүлэх
ухаан сургадаг.

1. Бүрэг номой байх,
2. Бие тоох, 3. Нэрэлхүү
байх явдал юм.

Энэ учраас ийм 3 саа-
дыг залуучууд бүхэн ав-
хааж самбаа зориг зол-
боо сайтай давж байх нь
чухад гэв.

БНМАУ-ын хөдөлмөрийн
баатар С.Цагааншүхэрт,
Б.Ажвал, Г.Алтанхүү,
БНМАУ-ын гавьяат багш
Сүрэн нар хөдөлмөрийн
ба оюуны хүмүүжлийг
олох арга замыг ахмад
үйснхнийхээ туршлагаас
олж авах, хөдөлмөрийн
сахилга батыг нарийн
чанд сахиж сурахыг зөв-
лөв.

Чуулга уулзалтад айм-
гийн төвийн 8 жилийн
дунд сургуулийн пионе-
рууд, НААУ-ийн газрын
хивсэн тасгийн илгээл-
тийн эзэд баяр хүргэв.

Дараа нь БНМАУ-ын
Ардын Их Хурлын Тэр-
гүүлэгч гишүүн, МХЗЭ-
ийн Төв Хорооны нэгдү-
гээр нарийн бичгийн дар-
га Ч.Пүрэвжав чуулга
уулзалтад оролцсон: ил-
гээлтийн эздэд үнэтэй
зөвлөлдөө өгч үг хэллээ.

Чуулга уулзалт дээр
БНМАУ-ын Ардын Их Хур-
лын Тэргүүлэгч гишүүн,
МХЗЭ-ийн Төв Хорооны

нэгдүгээр нарийн бичгийн
дарга Ч.Пүрэвжав ажил хө-
дөлмөр дээрээ амжилт бү-
тээл гаргасан ил-
гээлтийн эздэд МХЗЭ-ийн
Төв Хорооны шагналыг
гардуулав.

«Тэргүүний ажилчин за-
луу» алтан медалиар
НААУ-ийн газрын хивс-
чин Д.Долгоржав, Баян-
дэлгэрийн НААУ-ийн ан-
гийн оёдолчин Т.Дол-
горсүрэн, «Тэргүүний мал-
чин залуу» алтан меда-
лиар Эрдэнэ сумын сааль-
чин Г.Мягмарсүрэн, Баян-
зүрх сумын хоньчин
Ш.Баламгарав, «Тэргүү-
ний тариаланч залуу»
алтан медалиар Эрдэнэ-
сантийн ТАА-н транспор-
терчин С.Даваасүрэн,
МХЗЭ-ийн Төв Хорооны
хүндэт үнэмлэхээр Бор-
нуурын САА-н саальчин
Д.Надинцэцэг, Баян
сумын ямаачин Г.Ша-
равсамбуу, мөн баярын
бичгээр Сэргэлэн сумын
ногоочин Р.Сүхээ нарын
3 залуу шагнагдсаныг
гардуулав.

Мөн аймгийн АДХ-ын
гүйцэтгэх захиргааны шаг-
налаар Жаргалантын
САА-н гахайчин Ш.Шура,
Батсүмбэрийн САА-н
саальчин С.Эрдэнэцэцэг,
Лүн сумын хоньчин
Ц.Чанналдулам нарын 60
гаруй илгээлтийн эздийг
шагнав.

Чуулга уулзалт дээр
илгээлтийн эздэд БНМАУ-
ын хөдөлмөрийн баатрууд,
гавьяат цолтнуудаас үүрд
хадгалагдах улаан тугийг
дурсгаж хадгалууллаа.

Чуулга уулзалтад орол-
цогчид аймгийнхаа нийт
илгээлтийн эздэд, залуу
малчдад хандаж уриалга
гаргав.

Д.БАДАРЧ

Малчдын субботник

Баяншогтын САА-н
намын хороо, захиргаа,
аймгийн намын XVI ба-
га хурал угтаж малч-
дын хаврын суббота-
наар хийх ажлын тө-
лөвлөгөө гаргаж, 7 хо-
ногийн өндөр бүтээлийн
ажил зохиов.

Өндөр бүтээлийн аж-
лаар мал аж ахуйн бүх
суурийн 80-аад хувь нь
өвөлжөөгөө засварлаж
бууц-
6- гардууллаа.



Илгээлтийн эздийн чуулга уулзалтын нээлт

ХӨДӨЛМӨР НЭР ТӨР, АЛДАР ГАВЬЯАНЫ ҮЙЛС МӨН

«Мөнх дурсагдах алдар» сэдэвт аймгийн илгээлтийн эздийн анхдугаар чуулга уулзалт дээр аймгийн Намын хорооны хоёрдугаар нарийн бичгийн дарга, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний зөвлөлийн дарга Д. ДАМБАЖАМЦ—ын тавьсан илтгэл*



Илгээлтийн эздийн төлөөлөгчид, залуучууд аа!

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, гавьяат цолтон, алдар цуутан нөхөд өө!

Одоо илгээлтээр гарахаар бэлтгэж байгаа пионер сурагчид аа!

Энэ чуулга уулзалтанд уригдан оролцож байгаа эрхэм нөхөд өө! Залуу үеийнхний ахмад үеийнхний хувьсгалч, хөдөлмөрч, дайчин уламжлалаар хүмүүжүүлэхийн тулд аймгийн Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний зөвлөл, ХЗЭ-ийн хороо, АДХ-ын хүүхэд залуучуудын байнгын комисс хамтарч тодорхой сэдвээр жил бүр чуулга уулзалт зохиодог уламжлалтай болсон билээ.

1972 онд «Ахмадын сургаал алт», 1973 онд «Эрдэм мэдлэг-аз жаргалын түлхүүр» сэдэвт чуулга уулзалтууд зохиож, аймгийнхаа хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, ардын хувьсгалын партизан нартай пионер сурагчид, залуучуудын уулзалт хийлгэж, хувьсгалт дайчин уламжлалын баатарлаг жишээнээс яриуль үнэт сургамж зөвлөлгөө өгүүлсэн юм.

1974 онд аймгийн илгээлтийн эздийн анхдугаар чуулга уулзалтыг «Мөнх дурсагдах алдар» сэдвээр хийлгэж байна.

Энэ чуулга уулзалт нь илгээлтийн эздийн ажлыг дүгнэн арга туршлагыг нь солилцуулах, ахмад үеийнхний хөдөлмөрч баатарлаг уламжлалаар тэднийг хүмүүжүүлж тогтвор суурьшилтай ажиллуулж үр дүн гаргуулах зорилготой юм.

НЭГ. Намын уриа—эвлэлийн илгээлт

НӨХӨД ӨӨ!

Манай нам ерөнхий боловсролын зохих мэдлэгтэй залуучуудыг материал баялагийн үйлдвэрлэл дээр ажиллуулах бодлогыг тавьж МХЗЭ-ийн илгээлтийг гардан өгүүлэх замаар хэрэгжүүлж байна.

Нам, засгаас мал аж ахуйг тогтвортой хөгжүүлж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мал аж ахуйг хөдөлмөрийн нөөц, ажиллах хүчээр хангахын тулд V таван жилд ерөнхий боловсролын дунд сургууль төгсөгчдөөс 50 мянган охид, хөвгүүдийг ХАА-н үйлдвэрлэлд МХЗЭ-ийн илгээлтээр гаргаж ажиллуулахаар шийдвэрлэсэн явдал мөн. МАХН-ын энэхүү чухал шийдвэр амжилттай биелж сүүлийн 3 жилд 20 мянга орчим охид, хөвгүүд МХЗЭ-ийн илгээлтээр

ХАА-н үйлдвэрлэлд шилжин ажиллажээ. Зөвхөн тус аймагт 1971 оноос хойш ерөнхий боловсролын дунд сургууль төгссөн 1300 охид, хөвгүүд МХЗЭ-ийн илгээлтээр шууд үйлдвэрлэл дээр гарсаны 700 нь ХАА-н үйлдвэрлэлд шилжин үр бүтээлтэй ажиллаж байна.

Ийнхүү МАХН-ын уриалга, МХЗЭ-ийн илгээлтээр ахмад малчдын нэр төртэй залгамж халааг зохих мэдлэг боловсролтой залуучууд хүлээн авч байгаа нь мал аж ахуйг шинжлэх ухааны үндэстэй эрхлэн хөтөлж, цаашид тогтвортой хөгжүүлэн МАХН-ын программын заалт, намын эдийн засгийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх өргөн бололцоог бүрдүүлж байна.

МАХН-ын уриа дуудлага, МХЗЭ-ийн илгээлтээр манай залуу үеийнхэн эх орныхоо аль шаардлагатай газар явж түүхэн чухал үүрэг гүйцэтгэж ирсэн сайхан уламжлалтай билээ.

1959 оноос эхлэн олон зуун залуус эвлэлийн илгээлтээр атарт очсон билээ. Тэр залуусын ган хөлгийн дуунаар нойрноосоо сэргэсэн атар тал өнөөдөр шинэ хот, тосгон сүндэрлэн боссон, амуу тариа—аз жаргалын эх нутаг болжээ.

Баянцогт, Угтаалцайд гэсэн газар усны нэрийг атарт илгээлтээр очсон залуус өндөр бүтээлтэй САА-н нэр болгон хувиргажээ. Атрын залуусын маань түрүүч Жаргалантын САА-н тракторч М. Чойжамц, Угтаалын САА-н тракторч-комбайнч Г. Алтанхүү нар БНМАУ-ын хөдөлмөрийн баатар болтоо ажиллаж алдар нэрээ дуурсгалаа.

Ийм л залуустаа МХЗЭ илгээлтээ итгэл найдвартайгаа цуг гардуулдаг юм.

Энэ бол чухамдаа намын илгээлт, намын найдвар мөн.

Манай залуу үеийнхэн улс орныхоо хөгжлийн үе шат бүхэнд МАХН-ын уриа, МХЗЭ-ийн илгээлтээр сайн сайхан бүхнийг цогцлон байгуулсан хөдөлмөрч уламжлалтай билээ.

Үүний нэг тод илрэл бол ХАА-д малчин болохоор МХЗЭ-ийн илгээлтийг гардаж байгаа явдал юм.

НӨХӨД ӨӨ!

Манай мал аж ахуй хүн амыг хүнсээр, үйлдвэрийг түүхий эдээр хангадаг учраас нам, засаг, мал аж ахуйг тогтвортой өсгөж ашиг шинийг нэмэгдүүлэх асуудлыг бүх ард түмний үйл хэрэг болгон дэвшүүлэн тавьсан билээ.

Одоо энэ чухал салбарт хэдэн зуун залуучууд эвлэлийнхээ илгээлтээр очоод мэрийлт чармайлт гарган ажиллаж ихийг хийж бүтээж байна.

Хэдхэн хоногийн дараа 700 гаруй хөвгүүд, охид илгээлтээр гарч ажиллахад бэлхэн болоод байна.

ХОЁР. Илгээлтийн эздийн ажил амьдрал

Үйлдвэрлэл дээр гарсан илгээлтийн эздийг тогтвор суурьшилтай ажиллуулахад ихээхэн анхаарч ирлээ. Сурагчдад ХАА-н зохих хэмжээний дадлага олгох зорилгоор нийт дунд сургуулиудад «Малчны залуу халаа» бүлэг» хичээллүүлж, зарим сургуу-

лиудад мал аж ахуйн кабинет байгуулав.

Жил бүрийн тавдугаар сард «Мал маллах сайхан», «Намын уриа-илгээлтийн эздэд» зэрэг сэдэвт ажлыг зохиох, малчны сууриар тойрон аялал хийх, шилдэг малчдын арга туршлагыг судлах зэрэг илгээлтээр гарахын урьдчилсан бэлтгэлийг хийдэг боллоо.

Аймгийн ХЗЭ-ийн хороо, хөдөлмөрийн товчоотой хамтарч нийт илгээлтийн эздийн ажил байдалд хөдөлмөрийн үзлэг хийж дүнг аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаанд оруулж хэлэлцүүлсэн нь илгээлтийн эздийг тогтвор суурьшилтай ажиллуулахад чухал түлхэц өгсөн юм.

Олонхи сум илгээлтийн эздийн зөвлөлгөөнийг жил бүр хийж ажилыг нь дүгнэдэг сайхан уламжлал хэвшил болж байна.

Өнгөргөч онд мал сүргээ онд мэнд оруулж, төлөө сайн бойжуулсан илгээлтийн эзэн 23 залууг ЗХУ-ын Эрхүү, Москва, Ленинград хотоор жуулчлуулав.

Илгээлтийн эздэд улс ардын аж ахуйн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд их үүрэг гүйцэтгэж байна. Аймгийн хэмжээгээр сүүлийн 3 жилд ерөнхий боловсролын дунд сургууль төгсгөж МХЗЭ-ийн илгээлтээр шууд үйлдвэрлэл дээр гарч ажилласан охид хөвгүүдийн 81 хувь буюу 1054 нь үр бүтээлтэй ажиллаж байна. Илгээлтийн эзэн 500 шахам охид, хөвгүүд 82,1 мянган мал хариуцан маллаж жилд дунджаар 45,6 мянган төл бойжуулж байна. Саальчин 180 гаруй охид, 696,1 мянган литр сүү сааж улсад тушааж байна. Одоо илгээлтийн эздэд 47856 мал хариуцан төллүүлж, 938 төл илүү бойжуулсан амжилтаар чуулга уулзалтаа угтлаа.

Газар тариалангийн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа илгээлтийн эзэн 256 залуу 10,7 мянган га талбай хариуцан үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал тариалж жил бүрийн намар өндөр ургац хураан авдаг боллоо.

Аймгийн хэмжээгээр бэлтгэдэг байгалийн хадлангийн тавны нэг хувийг илгээлтийн эзэн залуу техникчид гүйцэтгэж байна.

Үйлдвэр, барилга, нэгдэл, САА-н туслах үйлдвэрт ажиллаж байгаа 200 шахам охид, хөвгүүд зөвхөн 1973 онд 3,5 сая гаруй төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Энэ бүхэн бол илгээлтийн эздээс эх орныхоо социалист байгуулалтанд оруулж байгаа үнэт хувь нэмэр мөн. Илгээлтийн эздийн дотроос арван хэдхэн насандаа БНМАУ-ын аварга ногоочин, тракторч-комбайнч, хадланч, малчны хүндэт цолыг 14, аймаг, сумын хөдөлмөрийн аварга цолыг 32 залуус хүртээд байна.

Мөн 20 шахам илгээлтийн эзэн МХЗЭ-ийн Төв Хорооны алтан медалиар шагнагдлаа.

Илгээлтийн эздийн дотроос ажиллахын зэрэгцээгээр боловсролоо ахиулахаар 8 дугаар ангид 233, 9 дүгээр ангид 83, 10 дугаар ангид 27 охид, хөвгүүд орой болон эцнээгээр сурч байна. Жаргалантын 10 жилийн дунд

сургуулийн 10 дугаар анги төгссөн хэсэг охид, хөвгүүд ангиараа мал аж ахуйн үйлдвэрлэлд гарч ажиллах санаачилга гаргаж 1968 онд эвлэлийн илгээлтээр Заамар сумын «Заамар» нэгдэлд очиж ажилласан билээ.

Тэд 4 жил үр бүтээлтэй ажилласныхаа дараа мэргэжлийн дагуу дээд сургуульд оруулан суралцуулж өгнө үү? гэсэн захидалыг 1972 онд МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю. Цэдэнбалд бичсэн юм.

Уг захидалыг хүлээж авсан манай нам, төрийн удирдагч нөхөр Ю. Цэдэнбал тэднийг ХАА-н дээд сургуульд оруулахаар шийдвэрлэсэн юм.

Тэд одоо оюутан болоод амжилттай суралцаж байна.

Ангиараа, хамт олноороо үйлдвэр, ХАА-д гарч ажиллаад ажил амьдралын баялаг туршлага хуримтлуулж, амласнаа нэр төртэй хэрэгжүүлж байсан олон сайхан жишээ бий. 1965 онд аймгийн үйлдвэрлэлийн хоршооллын төвийн артельд хивсний тасаг шинээр нээгдэж 8 дугаар анги төгссөн үе тэнгийн 33 охид анхны ажилчид нь болж байсан бол тэд өнөөдөр мэргэжилтэй хашир туршлагатай ажилчдын эгнээнд хүрч илгээлтийн эздийн багш нар болтоо өсчээ.

Энэ хугацаанд шинэ бүтээл оновчтой санал 10 гаруйг үйлдвэрлэлд нэвтрүүлсний дүнд тус тасаг хөдөлмөрийн бүтээмжийг 23 хувиар дээшлүүлж бүтээгдэхүүний өөрийн өртгийг 0,8 хувь хямдруулжээ.

Үйлдвэрлэлийн дотоод нөөц бололцоог илрүүлэн ашигласны дүнд байгууллагадаа дөрвөн түмэн төгрөгийн ашиг оруулсан байна.

Эрдэнэсант сумын «Саруул-амьдрал» нэгдлийн «Алтан-уул» бригадын хоньчин Д. Уртнасан 1971 онд сумынхаа дунд сургуулийн 8 дугаар анги төгсгөөд МХЗЭ-ийн илгээлтээр малчин болсон юм. Тэрээр сүүлийн 3 жилд 1024 хониноос 1060 төл бойжуулж, нэгдлийн үйлдвэрлэлийн даалгаврыг нэр төрөл дээр нь биелүүлж, МХЗЭ-ийн Төв Хорооны «Тэргүүний малчин» залуу алтан медалиар шагнагдсан бөгөөд илгээлтийн эздийн дотроос хамгийн анхны алтан медалиар энгэрээ мялаасан юм.

МХЗЭ-ийн Төв Хорооны алтан медалиар Батсүмбэрийн САА-н ногоочин, улсын аварга Х. Хандаа, Ж. Баатар, саальчин Ш. Пүрэвжав, Баян-өнжүүл сумын хоньчин М. Удаа, Баянжаргалан сумын үхэрчин Д. Дашпүрэв, Сэргэлэн сумын саальчин Г. Цэцэнбилэг, Угтаалын САА-н хоньчин Борис, Жаргалантын САА-н тракторч С. Таванцэцэг, ногоочин Ц. Сувдаа нарын 20 шахам илгээлтийн эздэд шагнагдаад байна. Лүн сумын «Энхтуул» нэгдлийн «Өгөөмөр» бригадын хоньчин илгээлтийн эзэн Ц. Чанцалдулам сүүлийн 3 жилд 100 хээлтэгч тутмаас 98—101 төл бойжуулж аймгийн ХАА-н нэгдлийн зөвлөлийн гишүүнээр сонгогдож ул-

(Үргэлжлэл нь III нүүрт)

Нөхөр Д. ДАМБАЖАМЦ—ын тавьсан илтгэлийн үргэлжлэл

Үргэлжлэл. (Түргүүч нь II нүүрт)

маар нэгдлийн холбооны IV их хуралд төлөөлөгчөөр оролцсон нь манай аймгийн илгээлтийн эздээс анх удаа улсын чанартай их хуралд оролцсон төлөөлөгч болсон юм.

Өндөрширээт сумын «Хөгжил» нэгдлийн трактор, илгээлтийн эзэн Н. Болд 1971 онд 7 дугаар анги төгсч илгээлтээр ХАА-н үйлдвэрлэл дээр гарч ажилласан юм. Н. Болд 1973 онд «КДП-4» хадуураар 40 хоногт 1690 тонн байгалийн хадлан хадгаж, 18 насандаа улсын аварга тракторчдын хүндэт цол хүртэж, МХЗЭ-ийн Төв Хорооны тэргүүний тариаланч алтан медалийг шагнуулж, ЗХУ-д жуулчлав.

Баяндэлгэр сумын НААУ-ний ангийн оёдолчин, илгээлтийн эзэн Т. Долгосүрэн 1972 онд оёдолчин болсноосой хойш жил бүрийн төлөөлөгчөөр 108—126,7 хувь биелүүлж, 1 жил 9 сард 40697 төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нормоо 10,2 мянган төгрөгөөр давуулж, хөдөлмөрийн бүтээмжийг 25,2 хувь дээшлүүлж залуучуудын нэрэмжит гавшгайч бригадын ахлагч, үйлдвэрийн дэргэдэх ХЗЭ-ийн үүрийн нарийн бичгийн даргаар идэвх зүтгэлтэй ажиллаж байна.

Эрхэлсэн ажил үйлс дээрээ сайхан амжилт гаргаж байгаа Баян-өнжүүл сумын «Хайрхан» нэгдлийн хоньчин, БНМАУ-ын тарга хүчний аварга малчин залуу О. Цэвэгмид, Баянцагаан сумын «Өрнөх-амьдрал» нэгдлийн хоньчин Г. Лхамсүрэн, Жаргалантын САА-н гахайчин Ш. Шура, Батсүмбэрийн САА-н ногоочин, БНМАУ-ын аварга Х. Хандаа, Баяндэлгэр сумын «Хэрлэн-баян» нэгдлийн саальчин н. Базарцэцэг, Эрдэнэсант сумын «Саруул-амьдрал» нэгдлийн хоньчин С. Товуудорж, НААУ-ний газрын хивсчин, аймгийн хөдөлмөрийн аварга Д. Долгоржав, Борнуурын САА-н саальчин Д. Нандинцэцэг, Баянцогтын САА-н тракторч Ч. Батжаргал, Эрдэнэсантын ТАА-н транспортерчин С. Даваасүрэн, Баянчандмань дахь туршлага фермийн хоньчин С. Баасандорж, Баянжаргал сумын саальчин Л. Нармандах, Мөнгөнморьт сумын саальчин Д. Очирдулам, Заамар сумын хоньчин С. Должинсүрэн,

Баянзүрх сумын хоньчин Д. Үүрцайх нарын зэрэг шилдэг тэргүүний илгээлтийн эздийг олныг нэрлэж болно.

Манай илгээлтийн эздийн зарим нь уран зохиолын гол баатар болж байгааг тэмдэглэхэд бахтай байна. Тухайлбал МХЗЭ-ийн илгээлтээр Эрдэнэсант сумын «Саруул-амьдрал» нэгдлийн хоньчин Дугарсүрэнгийн туслах малчнаар ажиллаж байгаа хоньчин хүү Дондогийн Сүхбаатарын тухай «Өглөөний наран айсуу» гэсэн баримтат тууж, мөн сумын хоньчин, илгээлтийн эзэн Д. Уртнасангийн тухай «Үүрийн цолмон» гэсэн найруулал хэвлэгдэн гарлаа. Ингэж өнөөдрийн илгээлтийн эздэд манай ахмад үеийнхний халааг нэр төртэй залгамжлагч гэдгээ амьдрал дээр бахархалтай харуулж байна.

Нам, захиргаа, ХЗЭ-ийн байгууллагаас тавих анхаарал халамж хэдийчлээ өндөр байснаар илгээлтийн эздэд маань найдвартай хүч болж байна.

Жаргалант, Батсүмбэр, Борнуур, Угтаал, Баяндэлгэр, Өндөрширээт, Эрдэнэсант, Баянжаргал сумын нам, захиргаа, ХЗЭ-ийн байгууллага илгээлтийн эздэдтэй ажиллах талаар чамгүй туршлага хуримтлуулж, үлгэр дамжал үзүүлж байна.

Тиймээс ч эдгээр сумдад илгээлтийн эздийн тогтвор суурьшил бусад сумтай харьцуулахад илүү сайн байна.

Жаргалантын САА-н нам, захиргаа, ХЗЭ-ийн байгууллага жил бүр илгээлтийн эздийн зөвлөлтөөн хийж ажил төрлийг нь дүгнэж, цаашид зохиох ажлыг тодорхойлж өгдөг уламжлалтай болжээ. Мөн тэргүүний хүмүүсийг дагалдуулан ажилдуулж, илгээлтийн эздийг төрөлжүүлэн мэргэшүүлж үр бүтээлтэй ажилдуулж байна.

Тус САА-н илгээлтийн эздэд 1972 оноос эхлэн аймгийн нийт илгээлтийн эздийг уриалж, 3 жилийн хугацаатай үүрэг аваад түүнийгээ амжилттай хэрэгжүүлж байна.

Ногоочин Ц. Сувдаа, Я. Бэлэг-эрдэнэ, Н. Баасанхүү, Я. Хас-эрдэнэ нар улсын аварга цол, хоньчин Даваадулам, барилгачин Нина, тахиачин Нэргүй нар сумын аварга, хоньчин Ю. Мянганбуу цахилгаанаар хонь хяргалтын аймгийн аварга цолоор шагнагда-

жээ. Батсүмбэрийн САА, илгээлтийн эздийг хүндэтгэлтэй хүлээн авч, тэдэнд аж ахуйнхаа байршил, үйлдвэрлэлийн онцлогийг танилцуулж, хариуцан ажиллах талбай, саалийн үнээ, техник зэргийг үзүүлж, хэд хичнээн төгрөгийн үнэт хөрөнгийг эзэмшиж, юу хийж бүтээхийг урьдчилан сайн ойлгуулж, ажилд томилдог байна. Мөн илгээлтийн эздийн бүрэлдэхүүнтэй залуучуудын гавшгайч бригад салаа байгуулж, илгээлтийн эздийн 90 хувийг СХ-ийн хөдөлгөөнд хамарчээ.

Ажлын ийм ахиц байвч илгээлтийн эздийн ажил амьдралд анхаарал тавих, тэднийг үр бүтээлтэй, тогтвор сууршилтай ажиллуулах талаар олгтой ажил зохиохгүй, урсгалд нь орхих, илгээлтээр очиж байгаа залуусыг ажилд авахгүй чирэгдүүлснээс Сэргэлэн, Заамар, Эрдэнэ сумдад сүүлийн 3 жилд МХЗЭ-ийн илгээлтээр гарсан охид, хөвгүүдийн 30,9—49,7 хувь нь ямар нэг шалтгаанаар үйлдвэрлэлээс хөндгөрчээ.

Иймээс дээрх сум—нэгдлүүд илгээлтийн эздэдтэй ажиллах ажиллагааг тавигдаж байгаа шаардлагын хэмжээнд хүртэл сайжруулах явдал чухал байна.

ГУРАВ. Хөдөлмөр-мөнх дурсагдах алдар мөн

НӨХӨД ӨӨ!

Одоо манай ард түмэн МАХН-ын программыг хэрэгжүүлж социализм байгуулах үйл хэрэгт хөдөлмөрийн гарамгай бүтээлийг гаргаж, алдар цуутны туршлагаар залуу үеийг хүмүүжүүлэх явдал зайлшгүй чухал болж байна.

Өнөөдөр тус аймагт ажиллаж амьдарч байгаа БНМАУ-ын хөдөлмөрийн баатрууд, БНМАУ-ын гавьяат цолтнууд зэрэг ахмад үеийнхний хувьсгалч дайчин, хөдөлмөрч уламжлалаас залуучуудыг суралцуулах зорилгоор «Мөнх дурсагдах алдар» сэдэвт аймгийн илгээлтийн эздийн анхдугаар чуулга уулзалтыг зохион явуулж байна. Манай хөдөлмөрийн алдар цуутнууд бол олон түмнийг хошуучлан маллайлагч, үлгэрлэн дагуулагч, сурган хүмүүжүүлэгчид билээ.

Ахмад тэргүүний хүмүүсийн туршлагыг залуучуудад эзэмшүүлэхээр тэргүүний малчин, ажилчдад илгээлтийн эздийг да-

галдуулан ажиллаж байгаа нь зохих үр дүнгээ өгч байна.

Одоо аймгийн хэмжээгээр ахмад тэргүүний 167 хүнийг 500 гаруй илгээлтийн эздэд даган ажиллаж байна.

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, Батсүмбэрийн САА-н ногоочин Я. Должинжав илгээлтээр гарсан хэсэг залуучуудыг сүүлийн 3 жил дагуулан ажиллаж хүнсний ногооны арвин ургац авах нарийн мэргэжил эзэмшүүлжээ. Энэ баатрын шавь нар нь 1971—1973 онд нормоо 135—389 хувь биелүүлэн 2—3,5 га талбайгаас авах ургацыг ганцхан гагаас авч ногоог арчилж, тордож ургуулах арга технологийг сайн эзэмшиж биеэ даан ажиллаж чаддаг болсон байна.

Я. Должинжав баатрын шавь илгээлтийн эзэн ногоочдын дотроос Ж.Баатар, Х.Хандаа, Алантаяа, Бадамханд, Хэнзээ нарын 5 залуу БНМАУ-ын аварга ногоочин болж, хоёр залуу МХЗЭ-ийн Төв Хорооны «Тэргүүний тариаланч» алтан медалийг шагнагдсан дээр ногоочин Наранхүү, Пагмадулам нар сум САА-н аварга цол хүртжээ.

Ингэж жинхэнэ хөдөлмөрийн талбараас баатрыг залгамжилсан ирээдүйн баатрууд төрөн гарч байна. Лүн сумын «Энх—туул» нэгдлийн хоньчин БНМАУ-ын аварга төлчин Дамдинсүрэнг 1971 оноос илгээлтийн эзэн 10 шахам залуу даган ажиллаж байна. Аварга төлчин Дамдинсүрэн илгээлтийн эздийг анх хүлээж аваад бригад, суурь, малчидтай танилцуулж дараа нь бэлчээр усны нөөц, худаг, усан санг хэрхэн ажиллуулахыг зааж өгдгийн дээр хонийг бэлчээрт хариулах арга, бэлчээрийн өвс ургамлын бүрэлдэхүүн зэргийг биечлэн хэлж туршлагын сургууль хийж үзүүлдэг ажээ.

Аварга төлчин Дамдинсүрэнгийн шавь, илгээлтийн эзэн М. Даваасүрэн 1973 онд 100 хэд тэгч тутмаас 99 төл бойжуулж ажлаараа шалгарч ЗХУ-д жуулчилжээ. Илгээлтийн эзэн Дангаасүрэн, Дуламсүрэн хоёр мөнд сүрэгтэн, Цэцэг сумын тэргүүний саальчин болж, хоньчин П. Долгоржав хариуцсан малын төлөө бүрэн бойжуулж энэ уулзалтанд оролцов.

(Төгсгөл нь IV нүүрт)

БНМАУ—ын хөдөлмөрийн баатар, гавьяат цолтнуудаас илгээлтийн эздэд залууст туг гардуулж, БНМАУ—ын хөдөлмөрийн баатар нөхөр Д. АРЬЯА—гийн хэлсэн үг

Хайрт залуус, илгээлтийн эздэд, охид, хөвгүүд ээ! Ард түмний минь цаглашгүй хүч чадал, оюун ухааны шавхагдашгүй өв сан нь алдарт намаа нягт хүрээлсэн цул нэгдэл нягтрал, ёс суртахууны эрхэм өндөр чанартаа байдаг юм.

Эвдэрч сарнишгүй энэ нэгдэл, социалист байгуулалтын өнөөгийн шатанд улам бүр бэхжиж, МАХН—ын XVI их хурлаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх хүчин зүйл болсоор байна.

Хамтын хөдөлмөр тэмцлийн дундаас төрж гарсан манай үеийн шинэ хүмүүсийн зорилго, үзэл санаа, уламжлалаас энэ хүчирхэг эв нэгдэл эх үүсвэрээ авсан юм.

Үл мартагдах баатарлаг явдал, хөдөлмөр тулалдаанд байгуулсан гавьяат үйлс, галчлалын эх оронч үзэл санаагаар манай уламжлал нэвтэрхий билээ.

Харийн дайсны эсрэг хувьсгалт тулал-

даан, социалист шинэ амьдрал байгуулахын төлөө хийсэн тэмцлийн явцад олон түмний баатарлаг үйлс олонтой тодрон гарч байлаа. Энэ бүхэн нь манай сайхан эх орны түүхийн он дарааллын хуудсанд үүрд мөнхжин тэмдэглэгдсэн юм.

Манай үеийн шинэ хүмүүс, ард түмний хээ ахмад үеийн хөдөлмөрч баатарлаг үйлсийг өндөр үнэлж ариунаар хадгалан, амьдрал хөдөлмөрийнхөө жишээ дууриалал болгогчийн хамт өөрсдийн охид, хөвгүүдийн хээ шударга үйлст ахмад үеийнхэн нь бахархаж, тэдэнтэй амин зүрхний холбоотой байдаг юм.

Өсвөр ба ид залуу насандаа ардын хувьсгалтай золгох хэмжээлшгүй аз жаргалтай төрсөн бид 70-аад оны залуус урам зориг бадруулсан хамтын хөдөлмөрт баатарлаж, ахмад үеийнхээ итгэлтэй халаа болж байгааг баяр бахдалтай харж байна.

Бид хуримтлуулж бий болгосон материалын ба оюун ухааны хамаг сайн сайхан бүхнээ залгамж үедээ дамжуулан үлдээдэг хүн төрөлхтний уламжлалыг дагаж, тэмцэл хөдөлмөрт өргөж явсан дайчин тугаа та бүхний чийрэг гарт атгуулж байна.

Ялалт амжилтын оройн сүлд нь болсон энэ тугт манай ард түмэн, ахмад үеийнхний асгаруулсан цус, дуслуулсан хөлс, ариун санаа, хамаг сайн сайхан бүхэн шингэсэн юм. Тэсвэр хатуужил, эрэлхэг зориг, эрдэм мэдлэг, их бүтээл та нараасаа хүссэний минь билэг тэмдэг энэ юм.

Манай ялгуусан туг та бүхний дээр үүрд намылаж, мянга мянган баатар, гавьяат үйлснийг төрүүлэх үйл хэрэгт зоригжуулах болтугай гэж ерөөж тус аймгийн хөдөлмөрийн баатрууд, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, гавьяат үйлснүүдээс та бүхэнд үүрдийн дурсгал болгож байгаа энэ тугийг гардуулъя.

Нөхөр Д. Дамбажамц—ын тавьсан илтгэлийн төгсгөл

Төгсгөл. (Түрүүч нь II, III нүүрт)

Эрдэнэ сумын «Туяа» нэгдлийн саальчин, намын гишүүн 60 настай эмгэн Г.Должин, илгээлтийн эзэн Г.Мягмарсүрэн, Б.Тунгалаг, З.Янжинлхам нарыг дагуулан ажиллаж, сүү саалийн ажилд сургасан байна. Шавь нартаа үнээ нээс их сүү саахын ач холбогдлыг тайлбарлан таниулж, яаж ажиллавал амжилтанд хүрч болдгийг уйгагүй зааж сургаснаар шавь нар нь эрлийз үнээ бүрээс 760—1001 литр сүү сааж, нормоор 15—43 хувь давуулан биелүүлж болжээ.

Сумын 3 удаагийн аварга саальчин Г.Должингийн шавь Г.Мягмарсүрэн мянгат саальчны эгнээнд хүрсний гадна Б.Тунгалаг сүү саалийн ажлаараа нөхдөөсөө түрүүлж өнгөрөгч онд ЗХУ-д жуулчилжээ.

Ингэж шавь нар нь багшийнхаа зааж сургасныг богино хугацаанд эзэмшиж, алдар нэрийг нь өндөрт өргөж явна.

Энэ мэтээр илгээлтийн эздийг ажил мэргэжилд сургах зорилгоор багш шавийн холбоо тогтоож, тэднийг тодорхой үйлдвэрлэл дээр үр бүтээлтэй ажиллуулж байгаа хүмүүсийн жишээнд Батсүмбэрийн САА-н саальчин, хөдөлмөрийн баатар А.Авирмэд, Борнуурын САА-н ногоочин, хөдөлмөрийн баатар С.Бадамсүрэн, Угтаагийн САА-н тракторч-комбайнч Г.Алтанхүү, Баян-өнжүүл сумын хоньчин, хөдөлмөрийн баатар Б.Ажваа, НААУ-ний газрын мастер З.Жамсран нарыг нэрлэхэд хангалттай байна.

ДӨРӨВ. 1973 оны төлөвлөгөөт ажлын дүн, цаашдын зорилт

НӨХӨД ӨӨ!

1973 он бол манай намын XVI их хурлаас баталсан V таван жилийн төлөвлөгөөний 3 дахь

жил, Төв аймаг байгуулагдсаны 50 жилийн ойн жил байлаа.

Манай аймгийн хөдөлмөрчдийн идэвхтэй хөдөлмөрийн үр дүнд эдийн засгийн гол салбар мал сүрэг өнгөрсөн оноосоо 83 мянгаар 1973 оны мал өсгөх төлөвлөгөөг 4000 гаруй малаар давуулан биелүүлж бахдам сайхан амжилт оллоо.

1973 онд тус аймгийн тариачид улс эх орныхоо хураан авсан үр тарианы 3-ны 1 хувьтай тэнцэх 178,7 мянган тонн ургац хурааж, ургац хураах улсын төлөвлөгөөг 162,5 хувиар биелүүлснээр өөрийнхөө түүхэнд байгаагүй аварга амжилтыг гаргаж ургац хураах талаар МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөлөөс зарласан уралдааны болзлыг САА 2, ХАА-н нэгдэл 3, тасаг 6, бригад 23 биелүүлж, суудлын 10, «УАЗ—452» авто машин 4, мотоцикл 23, мөн 430 мянган төгрөгөөр шагнаглала. Мөн улсын аварга тракторч, комбайнч, ногоочин цолоор 107 хүн шагнагдлаа.

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн Төв Хорооноос аймгуудын уралдаан дүгнэхэд ургац хураалт, га-гаас авах ургацын хэмжээг үлэмж нэмэгдүүлсэн учир тус аймаг БНМАУ-ын Засгийн газрын хүндэт жуух бичгээр шагнагдсан юм. Энэ бол манай аймгийн нийт хөдөлмөрчдийн баатарлаг шаргуу хөдөлмөрийн үр дүн мөн.

Тус аймгийн үйлдвэрүүд 1973 онд 13,6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 20,9 хувиар буюу 2357 мянган төгрөгөөр давуулж биелүүлжээ.

Өнгөрсөн оноосоо 4045 мянган төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэжээ.

Барилга, зам, тээвэр, худалдаа, холбоо зэрэг аж ахуйн салбарууд, арлын боловсрол, соёл, эрүүлйг хамгаалахын зорилтууд болон аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөүүд жигд бөгөөд амжилттай биелэгдлээ.

НӨХӨД ӨӨ!

Аймгийн Намын хорооны VI бүгд хурлаас 1974 онд мал өсгөх хөдөлшгүй төлөвлөгөөг төрөл бүр дээр нь биелүүлж 1975 оны мал өсгөх төлөвлөгөөг 1974 онд ерөнхий дүнгээр биелүүлэх том зорилтыг дэвшүүлэн тавьсан билээ.

Энэ нь 1973 онд тоологдсон мал дээрээ 85 мянган толгой мал цэврээр нэмэгдүүлж гэсэн үг. Мал аж ахуйн талаар тавигдаж байгаа зорилтыг биелүүлэхийн тулд юуны өмнө отор бэлчээрээр мал таргалуулж өргөн айлсалт зохион байгуулах, өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг үечилсэн графикаар хангааг туршлагыг нэвтрүүлэх хэрэгтэй.

И.Ю.Цэдэнбал, МАХН-ын Төв Хорооны II бүгд хурал дээр хэлэхдээ «Аливаа ажлын амжилт эцсийн эцэст тодорхой хүмүүсийн ажлын хариуцлагаас шалтгаална» гэж онцлон тэмдэглэснийг илгээлтийн эзэд байнга санаж ажиллах хэрэгтэй байна.

Манай аймаг энэ жил байгалийн хадлан 95,7 мянган тонныг бэлтгэн га тутмаас үр тариа 10,2, төмс 12,7, хүнсний ногоо 166,9, малын тэжээлийн ургамал 5,9 центнерээс доошгүйг хураан авч улсад үр тариа 75,7 мянган тонн, төмс 13,3 мянган тонн, хүнсний ногоо 14 мянган тонныг тушаана.

Аймгийн үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүний хэмжээг 12,3 сая төгрөгт хүргэж 88,4 сая төгрөгийн бараа гүйлгээ хийнэ.

Эдгээр зорилтыг биелүүлэхэд манай илгээлтийн эзэд их үүрэг

гүйцэтгэх ёстой. Төлөвлөгөөг нэр төрөл дээр нь биелүүлэхийн тулд социалист уралдааныг ажлын салбар бүрт өрнүүлэх, илгээлтийн эздэд тооцогт үүрэг а в а х, угтвар төлөвлөгөөтэй ажиллах, социалист уралдааны гэрээ байгуулах, бүтээлч төлөвлөгөө зохиох зэргээр өндөр идэвх санаачилга гарган ажиллавал зохино.

Илгээлтийн эзэн ажилчин, малчин, ногоочин, жимсчин, тракторч, комбайнч, хадланчин нэг бүр бүх ард түмний социалист уралдаанд шалгаралсын чуулга уулзалтанд оролцогчдын дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэн 6 өдрийн ажлыг 5 өдөрт хийж, таван жилийн төлөвлөгөөг дөрвөн жилд, энэ оны төлөвлөгөөг 10 сар 15 хоногийн дотор биелүүлэх хөдөлгөөнд идэвхтэй оролцох хэрэгтэй.

Эх орны маань ирээдүй, илгээлтийн эзэд та нарын гарт байна. Энэ сайхан орныхоо хөгжилт цэцэглэлтийн төлөө улам ихийг хийж бүтээх хэрэгтэй.

МХЗЭ-ийн илгээлтийн эзэд ээл Ажил, амьдралын замд тохиолдох алив бэрхшээлийг даван туулж, алдар цуут ахмад малчин, ажилчдынхаа хойчийг нэр төртэй залгамжлан, эх орныхоо хөгжил, цэцэглэлтэнд гавьяат үйлсийг бүтээж, энхрий хайрт намынхаа итгэл найдварыг нэр төртэй биелүүлж чадна гэдэгт аймгийн Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний зөвлөл, ХЗЭ-ийн хороо, АДХ-ын залуучуудын байнгын комисс итгэл төгс байна. МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тушаалдсаны 50 жилийн түүхт ойг угтаж, 1974 оны төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх үйлсэд хөдөлмөр сурлагын өндөр амжилт гаргахыг та бүхэнд уриалж байна.

ТОВШИН НҮҮДЭЛЛЭЖ БАЙНА

Хангайн уулсыг арлан уруудахад цэлгэрхэн хөндийн хойт урд талаар хазаарын мөнгөн товруу гэлтэй цагаан гэрүүд цайран харагдав.

Хонин сүргүүд «Сул асгасан сувд шиг» цэцгэрхэн хонин ухаадыг нөмрөн бэлчээрлэнэ. Өвлийг өнтэй, хаврыг хавтай өнгөрүүлдсэн малч хүмүүс туулай зоотой морь унаж хөндийн тоос босгон хатруулж малдаа явцаах нь замд тохиолдоно.

Бидний хэдэн хүмүүс МАХН-ын гишүүн С.Юндэн хэмээх малчинд очиж ажил байдалтай нь танилцав. Ажилд шалмаг байрын тэр хүн нэг ч малын хоргодолгүй 520 хониноос 521 хурга бөйжуулаад байгаа гэж яриагаа эхэлснээ манай суурь аймагт 16 дугаар сумандаа 3 дугаар байранд яваа гэлээ.

—Та аймаг суманд хэддүгээр байранд яваагаа яаж мэдэв гэвэл:

—Сумын намын хорооноос намын малчин гишүүдийн суурийг төл бөйжилт, малын зүй бус хо-

рогдлоор цуваагаар байр эзлүүлсэн жагсаалтыг тогтмол ирүүлдэг юм гэв.

Эднийх өвөлжөөгөө жин тан засварлаж, өвлийн бэлтгэлийг хийххэд мал ногоолуулах оторт яваа нь энэ ажээ Нүүдэл хийхдээ отрын хөнгөн гэртэй нь нэг морин тэргэнд аччихаж багтах юм. Отрын гэртээ оёдлын машин радио, бромметр, дэвсгэр, хувцас, гал тогооны хэрэгсэл, хүнсний зүйл төдийхөн авч явдагаас олон нүүдэл хийхэд, ажил ороод байх юм алга.

С.Юндэн уралдааны үүргээ 600 грамм ноолуур, 4 кг хялгасаар давуулжээ.

Эдний хонь юухан ч харсан намын хонь шиг үргэн хуйларч байгаа нь өвөл гарган орж, хавар эрт ногоонд гарсных юм.

МАХН-ын гишүүн, хоньчин С.Юндэн хургыг хол явуулахгүй ногоо идүүлэхэд маш түргэн өнгө засч сайхан болж байна.

Одоо бид 1—2 хоногоос Хөшөөт, Баян, Тариат дамнан Туул хүрч нүүдэллэ-

хээр замдаа ороод байгаа нь энэ гэж ярилаа.

Бид эндээс ойролцоох нэгэн суурьт очвол, сумандаа анх удаа Б.Ажваагийн туршлагаар отор бэлчээрээр малаа таргалуулж, малчдаа хошуучилсан ахмад хоньчин Н.Санжаагийнх байлаа.

Тэрээр мөн л маргааш Цавын ар дамжаад Хөшөөт орно, цааш нүүнэ гэж ярилаа.

Санжаа бол сумын 5 удаагийн аварга, түүний гэргий Ч.Цэвээндүлам БНМАУ-ын аварга малчин юм. Эднийх 1973 онд 36 удаа нүүсэн, энэ оны уралдааны үүргээр 50 удаа нүүдэл хийх юм байна. Одоо 3 дахь нүүдэл дээрээ явна. Нолонин 1060 шүдлэн хонин дунджаар 72 кг-д хүргэсэн ололтоо бататгахаар товшин нүүдэллэж эхэлжээ. Саяхны байдлаар хонь нь 55—60 кг жинтэй байгаа ажээ.

Баянцогтын САА-д 1972 онд тус сумын «Ажваа» нэг байсан бол одоо 12 «Ажваа»-тай болж тэд хаяа хаяагаа дэрлэн нутгийн аль сайныг шилэн нүүдэллэж явна.

Н.Санжаа ярихдаа отор бэлчээрээр анх гарахад малчид нэг ихтаашаахгүй байлаа. Мал их таргалахаар ноос, сүү бүхий л зүйл нь давж биелээд нэмэгдэл хөлс аваад жинхэнэ амт шимтийг нь аваад ирэхээр шаардлага шахалтгүй өөрсдөө аяндаа хөдөлчихдөг болдог юм байна.

Мал ч бас сурах юм.

Хоргол нэмэгдээд 4—5 хоног болоход илт тогтворгүй болоод ирэх юм гэж ярилаа.

Үнэхээр ч тийм юм.

Эдгээр малчдад мал маллагааны уламжлалт хам хөмрөгийг баяжуулсан олон сайхан туршлага байгаа нь илт байна.

Түүнийг нь малчиндаа дараа толилуулья.

Д.ТОВУУ



Цэцэрлэг сайхан, цэцгүүд гоёхон

Судалбар зураг

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧИЙГ Б.ЦЭРЭНДАН